



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны Захирагчийн ажлын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2023/70/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.bulgan@audit.gov.mn">www.bulgan@audit.gov.mn</a> Булган аймаг Булган сум 2023 он</p>	<p>Булган аймаг дахь ТАГ-н дарга, Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 89009802 Цахим хаяг: <a href="mailto:erdeneb@audit.gov.mn">erdeneb@audit.gov.mn</a> Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 99057478 Цахим хаяг: <a href="mailto:enhtsoodolj@audit.gov.mn">enhtsoodolj@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Утас: Цахим хаяг: Аудитор: Б.Золжаргал Утас: 90119931 Цахим хаяг: <a href="mailto:zoljargalb@audit.gov.mn">zoljargalb@audit.gov.mn</a></p>
---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
  2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
  3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
    - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
    - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
    - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
    - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
  4. Аудитын тайлан .....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
  6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.08.24 № 109  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ХАНГАЛ СУМЫН ХЯЛГАНАТ  
ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН  
АЛБАНЫ ДАРГА А.СОД-ЭРДЭНЭ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангал сумын Хялганат тосгоны Захирагчийн ажлын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангал сумын Хялганат тосгоны Захирагчийн ажлын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Хангал сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09/03 тогтоолоор Хялганат тосгоны 2022 оны төсвийн орлогыг орон нутгийн төсвөөс 388,113.0 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 9,500.0 мянга, урд оны үлдэгдлээс 12,582.3 мянга нийт 410,195.3 мянган төгрөгөөр баталсан.

### Аудитын гол асуудал

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгонд байрлах Нийслэлийн өмчид бүртгэлтэй "Үртсэн шахмал түлшний үйлдвэр" ОНӨААТҮГ-ын 52 нэрийн 2,191,982.2 мянган төгрөгийн анхны өртөг бүхий, 1,015,763.9 мянган төгрөгийн

D:/bichighereg/2022A4foot

006020115

үлдэх өртөгтэй хөрөнгийг 746,801.6 мянган төгрөгийн өртгөөр шилжүүлэх Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 47 тоот тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/887 тоот захирамж, хөрөнгө бүртгэлд тусгах аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12/18 тоот тогтоолын дагуу хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэлд тусгасан. Мөн ажил хүлээлцэх явцад 6,599.7 мянган төгрөгийн анхны үнэ бүхий 10 нэр төрлийн тавилгыг байгууллагын 210602-Тавилга, эд хогшлын зардлаас шилжүүлж худалдаж авч бүртгэлд тусгасан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Захирагч үр дүнгийн гэрээгээр 6 хөтөлбөрийн 116 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан, гэрээний биелэлт 86.1 хувьтай дүгнэгдсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
			/төгрөгөөр/
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,585,230.00</b>	<b>33,694,520.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	3,265,360.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	3,265,360.00	-
3351	Байгууллагаас авах авлага	3,265,360.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	9,319,870.00	25,534,520.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	635,000.00	635,000.00
35110	Тусгай зориулалттай материал	635,000.00	635,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	8,684,870.00	24,899,520.00
35410	Бичиг хэргийн материал	829,870.00	979,870.00
35420	Аж ахуйн материал	-	7,900,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	6,730,050.00
35450	Барилгын засварын материал	1,110,000.00	1,564,100.00
35460	Хүнсний материал	30,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	6,715,000.00	7,725,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	8,160,000.00
36300	Тэжээлийн нөөц	-	8,160,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,495,341,920.40</b>	<b>3,278,783,275.29</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,495,341,920.40	3,278,783,275.29
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,426,381,253.70	3,197,138,608.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	280,011,396.01	453,341,692.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(73,260,546.35)	(97,712,050.19)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	181,000,000.00	175,160,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(155,440,149.61)	(85,377,594.33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	56,297,237.00	661,826,891.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,647,766.43)	(41,004,889.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,532,660.00	40,168,360.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,954,331.40)	(11,635,094.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,801,776,688.00	2,801,776,688.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(660,543,333.52)	(760,064,794.48)
39217	Ном	609,400.00	60,659,400.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	68,960,666.70	81,644,666.74
39301	Програм хангамж	2,100,000.00	2,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(653,333.30)	(1,353,333.26)
39303	Бусад биет бус хөрөнгө	67,514,000.00	80,898,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,507,927,150.40</b>	<b>3,312,477,795.29</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,265,360.00</b>	<b>30,044.16</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,265,360.00	30,044.16
<b>413</b>	<b>Өглөг</b>	3,265,360.00	30,044.16
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	30,044.16
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	3,265,360.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	3,265,360.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,170,711,800.90</b>	<b>3,312,447,751.13</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,170,711,800.90	3,312,447,751.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	333,949,989.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,069,302,777.79	2,877,088,738.52
51210	Өмнөх үеийн үр дүн	2,069,302,777.79	2,069,302,777.79
51220	Тайлант үеийн үр дүн	-	807,785,960.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	101,409,023.11	101,409,023.11
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,173,977,160.90</b>	<b>3,312,477,795.29</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>390,765,210.70</b>	<b>1,350,206,936.85</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,906,780.70</b>	<b>959,194,296.85</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,906,780.70	959,194,296.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,906,780.70	33,502,696.85
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,906,780.70	20,920,396.85
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	12,582,300.00
120017	үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -үндсэн хөрөнгө		903,785,550.00
120018	үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал		21,906,050.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>383,858,430.00</b>	<b>391,012,640.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,050,000.00	-
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	3,050,000.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	31,271,390.00	17,764,140.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,350,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	11,592,040.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,953,390.00	1,872,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	968,000.00	4,300,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	349,537,040.00	373,248,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	349,537,040.00	373,248,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>442,277,207.13</b>	<b>542,420,976.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>442,277,207.13</b>	<b>542,420,976.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	438,037,592.15	532,826,805.72
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	162,466,873.52	171,694,722.00
210101	Үндсэн цалин	118,613,758.00	122,517,398.00
210102	Нэмэгдэл	22,065,942.52	21,151,963.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	10,407,500.00
210104	Урамшуулал	-	10,260,575.00
210105	Гэрээт ажлын хөлс	21,787,173.00	7,357,286.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,306,165.54	21,468,258.68
210201	Тэтгэврийн даатгал	14,771,057.65	14,976,825.36
210202	Тэтгэмжийн даатгал	1,641,421.81	1,747,217.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,313,137.44	1,527,096.05
210204	Ажилгүйдлийн даатгал	318,394.78	278,047.96
210205	Эрүүл мэндийн даатгал	3,262,153.86	2,939,071.79
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	66,342,776.66	70,621,440.00
210301	Гэрэл, цахилгаан	8,719,676.66	11,160,000.00
210302	Түлш, халаалт	53,580,860.00	53,581,440.00
210303	Цэвэр, бохир ус	3,819,600.00	5,880,000.00
210304	Байрны түрээс	222,640.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,493,116.00	23,649,470.93
210401	Бичиг хэрэг	2,414,750.00	2,113,500.00
210402	Тээвэр, шатахуун	9,777,860.00	9,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,582,330.00	1,548,170.93
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн	3,000,000.00	10,000,000.00

	устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	623,800.00	487,800.00
210408	Бараа материал акталсны зардал	94,376.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>500,000.00</b>	<b>1,299,909.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	1,299,909.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22,282,300.00</b>	<b>23,114,320.00</b>
210604	Урсгал засвар	22,282,300.00	23,114,320.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,620,000.00</b>	<b>7,555,400.00</b>
210701	Гадаад албан томилолт	-	3,558,400.00
210702	Дотоод албан томилолт	1,620,000.00	3,997,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,281,890.00</b>	<b>14,888,990.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,450,040.00	14,387,140.00
210803	Даатгалын үйлчилгээ	222,150.00	156,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,700.00	125,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	121,000.00
210807	Газрын төлбөр	385,000.00	98,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>137,744,470.43</b>	<b>198,534,295.11</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,040,570.00	47,886,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	1,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,203,900.43	149,648,295.11
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,239,614.98</b>	<b>9,594,170.40</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>706,600.00</b>	<b>1,470,469.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	706,600.00	1,470,469.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,533,014.98</b>	<b>-</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,533,014.98	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>8,123,701.40</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,123,701.40
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(51,511,996.43)</b>	<b>807,785,960.73</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,827,204.73</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,827,204.73	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(1,827,204.73)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(53,339,201.16)</b>	<b>807,785,960.73</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>387,715,210.70</u></b>	<b><u>427,780,696.85</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,906,780.70</b>	<b>33,502,696.85</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,906,780.70	33,502,696.85
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	6,906,780.70	33,502,696.85
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,906,780.70	20,920,396.85
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	12,582,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>380,808,430.00</b>	<b>394,278,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	31,271,390.00	21,029,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,350,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	14,857,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,953,390.00	1,872,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	968,000.00	4,300,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	349,537,040.00	373,248,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	349,537,040.00	373,248,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>355,113,110.70</u></b>	<b><u>398,476,596.85</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>355,113,110.70</b>	<b>398,476,596.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>350,873,495.72</b>	<b>388,882,426.45</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	162,466,873.52	171,819,328.00
210101	Үндсэн цалин	118,613,758.00	122,642,004.00
210102	Нэмэгдэл	22,065,942.52	21,151,963.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	10,407,500.00
210104	Урамшуулал	-	10,260,575.00
210105	Гэрээт ажлын хөлс	21,787,173.00	7,357,286.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,306,165.54	21,313,608.52
210201	Тэтгэврийн даатгал	14,771,057.65	14,830,938.24
210202	Тэтгэмжийн даатгал	1,641,421.81	1,744,713.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,313,137.44	1,526,094.55
210204	Ажилгүйдлийн даатгал	318,394.78	277,797.40
210205	Эрүүл мэндийн даатгал	3,262,153.86	2,934,064.47
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	66,120,136.66	70,621,440.00
210301	Гэрэл, цахилгаан	8,719,676.66	11,160,000.00
210302	Түлш, халаалт	53,580,860.00	53,581,440.00
210303	Цэвэр, бохир ус	3,819,600.00	5,880,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,622,530.00	23,649,470.93
210401	Бичиг хэрэг	1,613,500.00	2,113,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,956,500.00	9,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,582,330.00	1,548,170.93
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	10,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	470,200.00	487,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	500,000.00	1,299,909.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	1,299,909.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	22,620,400.00	22,602,920.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	150,000.00
210602	Тавилга	-	165,000.00
210604	Урсгал засвар	22,620,400.00	22,287,920.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,620,000.00	7,555,400.00
210701	Гадаад албан томилолт	-	3,558,400.00
210702	Дотоод албан томилолт	1,620,000.00	3,997,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,132,890.00	23,620,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,201,040.00	23,118,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	222,150.00	156,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,700.00	125,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	-
210807	Газрын төлбөр	385,000.00	98,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	50,484,500.00	46,400,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,984,500.00	45,400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	1,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,239,614.98</b>	<b>9,594,170.40</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	706,600.00	1,470,469.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	706,600.00	1,470,469.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	3,533,014.98	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,533,014.98	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	8,123,701.40
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,123,701.40
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>32,602,100.00</u></b>	<b><u>29,304,100.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>34,702,100.00</b>	<b>29,304,100.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>34,702,100.00</b>	<b>29,304,100.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	34,702,100.00	29,304,100.00
222001	Тоног төхөөрөмж	6,200,000.00	22,819,400.00
223001	Бусад хөрөнгө	28,502,100.00	6,484,700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(34,702,100.00)</u></b>	<b><u>(29,304,100.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(2,100,000.00)</b>	<b>0.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	333,949,989.50	101,796,443.11	463,249,264.95	-	898,995,697.56
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	387,420.00	-	387,420.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>333,949,989.50</b>	<b>101,796,443.11</b>	<b>463,636,684.95</b>	-	899,383,117.56
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(387,420.00)	-	-	(387,420.00)
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	1,605,666,092.84	-	1,605,666,092.84
C08	<b>2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>333,949,989.50</b>	<b>101,409,023.11</b>	<b>2,069,302,777.79</b>	-	2,504,661,790.40
D01	<b>2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл</b>	<b>333,949,989.50</b>	<b>101,409,023.11</b>	<b>2,069,302,777.79</b>	-	2,504,661,790.40
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>333,949,989.50</b>	<b>101,409,023.11</b>	<b>2,069,302,777.79</b>	-	2,504,661,790.40
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	807,785,960.73	-	807,785,960.73
D09	<b>2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>333,949,989.50</b>	<b>101,409,023.11</b>	<b>2,877,088,738.52</b>	-	3,312,447,751.13

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	410,195,300.00	398,627,495.45
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	410,195,300.00	369,323,395.45
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	408,724,800.00	367,852,926.45
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	181,500,800.00	171,819,328.00
210101	Үндсэн цалин	134,015,300.00	122,642,004.00
210102	Нэмэгдэл	32,643,800.00	21,151,963.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	580,000.00	10,407,500.00
210104	Урамшуулал	1,703,400.00	10,260,575.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,558,300.00	7,357,286.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,894,400.00	21,313,608.52
210201	Тэтгэврийн даатгал	15,647,300.00	14,830,938.24
210202	Тэтгэмжийн даатгал	1,861,800.00	1,744,713.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,489,400.00	1,526,094.55
210204	Ажилгүйдлийн даатгал	372,400.00	277,797.40
210205	Эрүүл мэндийн даатгал	3,523,500.00	2,934,064.47
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	70,621,500.00	70,621,440.00
210301	Гэрэл, цахилгаан	11,160,000.00	11,160,000.00
210302	Түлш, халаалт	53,581,500.00	53,581,440.00
210303	Цэвэр, бохир ус	5,880,000.00	5,880,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,699,500.00	23,649,470.93
210401	Бичиг хэрэг	2,113,500.00	2,113,500.00
210402	Тээвэр, шатахуун	9,500,000.00	9,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,586,000.00	1,548,170.93
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,000,000.00	10,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	487,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,300,000.00	1,299,909.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,300,000.00	1,299,909.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	51,891,500.00	22,602,920.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,000,000.00	150,000.00
210602	Тавилга	6,599,700.00	165,000.00
210604	Урсгал засвар	22,291,800.00	22,287,920.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,758,400.00	7,555,400.00
210701	Гадаад албан томилолт	3,558,400.00	3,558,400.00
210702	Дотоод албан томилолт	4,200,000.00	3,997,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,658,700.00	2,590,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,089,000.00	2,089,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	224,300.00	156,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,700.00	125,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	121,000.00
210807	Газрын төлбөр	98,700.00	98,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	46,400,000.00	46,400,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,400,000.00	45,400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,470,500.00	1,470,469.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,470,500.00	1,470,469.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,470,500.00	1,470,469.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>29,304,100.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	29,304,100.00
222001	Тоног төхөөрөмж	-	22,819,400.00

223001	Бусад хөрөнгө	-	6,484,700.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	410,195,300.00	406,751,196.85
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	388,113,000.00	373,248,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	388,113,000.00	373,248,500.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	22,082,300.00	33,502,696.85
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,500,000.00	20,920,396.85
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	12,582,300.00	12,582,300.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>21,029,500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>21,029,500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	21,029,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	21,029,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	21,029,500.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	21,029,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	21,029,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	14,857,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,872,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,300,000.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

2022 онд иргэдээ дээдэлсэн, бүтээлч, чадварлаг төрийн захиргааны байгууллага болох зорилго дэвшүүлэн, хотожсон тосгон ба Булган аймгийн зүүн хойд бүсийн хөгжлийн тулгуур төв болох зорилт тавин ажиллажээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант онд тухайн байгууллагад мөрддөг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоол, 05 дугаар сарын 11-ний өдрийн 192 дугаар тогтоолд тус тус өөрчлөлт орсон байна.

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны хууль, Сангийн сайдын 2019 оны 05 дугаар тогтоол, Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаалаар батлагдсан албан томилолтын зардлын тарифт өөрчлөлт оруулах тухай тушаал, Төрийн болон албаны нууцын тухай хуулиудад өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хангал сумын Хялганат тосгоны ЗАА-ны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузель сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 тоот захирамжаар батлагдсан аймгийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрддөг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Хангал сумын Хялганат тосгоны ЗАА-ны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 804,550.64 мянган төгрөгөөр буюу 32.1 хувиар өссөн байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	3,265.36	0.00	(3,265.36)
Бараа материал	9,319.87	25,534.52	16,214.65
Үндсэн хөрөнгө	2,495,341.92	3,278,783.27	783,441.35
Нийт хөрөнгө	2,507,927.15	3,312,477.79	804,550.64
Өр төлбөр	3,265.36	30.04	(3,235.31)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,170,711.8	3,312,447.75	1,141,735.95
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,173,977.16	3,312,477.79	1,138,500.63

Дээрх хүснэгтээс харахад:

- ✚ Авлага өмнөх оноос 3,265.36 мянган төгрөгөөр буурсан нь 2021 онд төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөрийн авлагыг барагдуулж ажилласантай холбоотой.
- ✚ Бараа материалын дансны үлдэгдэл 25,534.5 мянган төгрөг болж өмнөх оноос 16,214.6 мянган төгрөгөөр өссөн нь тэжээлийн нөөц 8,160.0 мянган, үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгасан “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-аас шилжиж ирсэн 6,876.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 165.0 мянган төгрөгийн үнэ бүхий вакум цонхыг байгууллагын төсвөөс худалдан авч бүртгэлд тусгасан, мөн тайлант онд худалдан авч зарцуулагдаагүй аж ахуйн материалын үлдэгдэл зэргээс шалтгаалжээ.
- ✚ Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,278,783.3 мянган төгрөг болж өмнөх оноос 783,441.3 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-гийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгө 163,860.0 мянга, өөрийн хөрөнгөөр худалдан авсан 29,304.1 мянга, “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-аас шилжиж ирсэн барилга, байгууламж 173,330.3 мянга, машин тоног төхөөрөмж 553,211.2 мянга, 13,384.0 мянган төгрөгийн газрыг үнэ төлбөргүй хүлээж авч бүртгэлд тусгасан. Мөн 6,434.7 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг худалдан авч бүртгэлд тусгаснаас шалтгаалжээ. 2022 онд 80,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл акталсан байна.
- ✚ Оны эхний үлдэгдэл 2021 онд төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр 3,265.36 мянган төгрөгийн өглөгийг барагдуулж, нэмж 30.0 мянган төгрөгийн ХХОАТ-н өглөг үүссэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 379,810.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,500.0 мянган төгрөгөөр санхүүжих нийт зарлагыг 381,310.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, хөлс нэмэгдэл урамшил зардлыг 1,266.7 мянга, ажил олгогчоос төлөх НДШ-н зардал 322.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5,342.8 мянга, нормативт зардал 290.0 мянга, эд, хогшил урсгал засварын зардлыг 17,401.9 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 149.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж, хангамж, бараа материалын зардлыг 3,223.5 мянга, томилолт зочны зардлыг 1,675.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 20,121.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 8,795.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталснаас харахад төсвийн төлөвлөлтийг бодитой тооцоо судалгаатай тооцоогүй байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг Хангал сумын ИТХ-н 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 5/30 тоот тогтоолоор 280,313.2 мянга, 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 9-р хуралдааны 09/03 тогтоолоор 129,882.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 410,195.3 мянган төгрөг болгон тодотгосон байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 373,248.5 мянга, урд оны үлдэгдлээс 12,582.3 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 20,920.4 мянган төгрөгөөр тус тус санхүүжигдэж зарцуулагдаагүй үлдэгдэл 8.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 398,627.5 мянган төгрөг буюу 98 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 8,123.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106- ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	406,751.1	398,627.5	8,123.6	98%
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал Үндсэн үйл ажиллагааны зардал	330,083.1	321,959.5	8,123.6	98%
1.2	80112-Нийтлэг үйлчилгээ	20,197.6	20,197.4	0.15	100%
1.3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,470.5	1,470.47	0.03	100%
1.4	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	30,000.0	30,000.0	0.00	100%
1.5	82201 -Гэмт хэргээс урьдчилан сэргийл	10,000.0	10,000.0	0.00	100%
1.6	82212-Хур хог хаягдал, орчны бохирдол	10,000.0	10,000.0	0.00	100%
1.7	82801-Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0.00	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	21,029.5	21,029.5	0.00	100%
		21,029.5	21,029.5	0.00	100%

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Нэмэлт санхүүжилтийн орлогын эх үүсвэрээр задалбал:

- ✚ Урд оны авлага усны төлбөрийн авлага 8,357.4 мянган төгрөг
- ✚ Цэвэр орчин цэмцгэр Булган аяны хүрээнд 1,500.0 мянган төгрөг
- ✚ Хөдөө аж ахуйн тооллогын зардал 1,832.1 мянган төгрөг
- ✚ Баяр наадмын зардал ОНХС-с 4,000.0 мянган төгрөг
- ✚ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардал 300.0 мянган төгрөг
- ✚ Байгалын гамшгийн эрсдэлийг бууруулах зардал 5,000.0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус хийгдсэн.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хангал сумын Хялганат тосгоны ЗАА-ны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь ТАГ-н аудитор Б.Золжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хангал сумын Хялганат тосгоны ЗАА-ны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь ТАГ-т 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлаас буюу 398,161.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,972.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 4,479.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоолгүй ажиллаж 8.1 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

[www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 20 удаагийн 311,979.3 мянган төгрөгийн орлогын мөнгөн гүйлгээг хугацаанд мэдээлж, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 удаагийн 89,844.67 мянган төгрөгийн мөнгөний зарлагын

гүйлгээ мэдээлэхээс 10 удаагийн 65,177.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 68 удаагийн 821,549.4 мянган төгрөгийн тушаал шийдвэр мэдээлэхээс 31 удаагийн 779,104.5 мянган төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

9-р сард 48,500.0 төгрөгийн хэвлэл захиалсан. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-д заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Хэвлэл захиалгын үнийг аймгийн орлогын дансанд төвлөрүүлэх, төлбөрийн акт тогтоох

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй байна.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Хүснэгт: 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт					
Зөвлөмж	2	0.0	2	0	100%
Албан шаардлага	2	253,199.1	1	18,672.3	7.3%
<b>Нийт дүн</b>					

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн хэмнэлтийн тухай хууль, шилэн дансны мэдээг хуулийн хугацаанд, үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх албан шаардлага хүргүүлсэн боловч 2022 онд шилэн дансны цахим системд мэдээлэх нийт 1,223,373.4 мянган төгрөгийн ажил гүйлгээ мэдээлэхээс 379,091.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг мэдээлж, 844,281.4 мянган төгрөгийн мэдээг мэдээлэлгүй орхиж биелэлт 31 хувьтай байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын дагуу үйл ажиллагааны зардлыг хуримтлуулан бүртгэсэн эсэх асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс дансны давхар бичилт хийгээгүй шууд зардалд бичсэн 19,749.3 мянган төгрөгийн 4 ажил гүйлгээг аудитын явцад залруулав.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Шатахууны зарцуулалтыг шалгахад авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг 674.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан “Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хэтрүүлэн зарцуулсан шатахууны үнийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

5.1.2 2022 оны 9 дүгээр сард 48.5 мянган төгрөгийн хэвлэл захиалсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.3.”хэвлэлийн захиалгын төлбөр” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хэвлэл захиалгын үнийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх, төлбөрийн акт тогтоох

### 5.2 Албан шаардлага

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөрөнгийн тооллогыг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу хийж баталгаажуулаагүй, хөрөнгийг эх хэлээрээ бичиж ерөнхий нэршлээр бүртгээгүй.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг бүртгэхдээ хөрөнгийн ерөнхий нэршлээр, эх хэлээрээ бүртгэлд тусгаж, хөрөнгийн тооллогыг зохих хууль, журмын дагуу хийж, үр дүнг тайлагнаж хэвших

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой 4 ажил гүйлгээ	4	19,749.3					4	19,749.3				
Дүн	4	19,749.3					4	19,749.3				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жишиг нормоос хэтрүүлэн зарцуулсан	1	674.4	1	674.4								
Эдийн ангилал зөрчиж зарцуулсан	1	0.0			1	0.0						
Дүн	2	674.4	1	674.4	1	0.0						

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээ мэдээлээгүй	1	844,281.9			1	844,281.9		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хэвлэл захиалсан	1	48.5	1	48.5				
Дүн	2	844,330.4	1	48.5	1	844,281.9		

